

2024-05-31 0000011

БҮРТГЭВ-03

"Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам"-ын  
Хавсралт 4-а

## АЛБАН МЭДЭГДЭЛ

Улаанбаатар хотын бонд

Огноо: 2024/05/31

Энэхүү Албан мэдэгдэл нь нийтэд санал болгон бонд гаргах Улаанбаатар хот /Нийслэл/-ын үйл ажиллагааны ерөнхий стратеги төлөвлөгөө, татан төвлөрүүлсэн хөрөнгөөр санхүүжүүлэх үйл ажиллагаа, түүний Монгол улсын Засгийн газар /Нийслэлийн баримталж байгаа бодлогод нийцсэн байдал, мөн тэдгээрийн хэрэгжилт, үр дүн, хөрөнгийн зарцуулалттай холбоотой мэдээллийг тайлагнахтай холбоотой төлөвлөгөөг хөрөнгө оруулагч, холбогдох талуудад толилуулах зорилготой юм.

### 1. Ерөнхий мэдээлэл


- |      |   |  |
|------|---|--|
| 1.1. | Бонд гаргагч аймаг/нийслэл хотын нэр:   | Нийслэлийн Засаг Даргын Тамгын газар   |
| 1.2. | Бонд гаргахтай холбоотойгоор гаргасан Иргэдийн төлөөлөгчдийн хурлын шийдвэрийн огноо, дугаар: | Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 04 сарын 29-ний өдрийн 48 тоот тогтоол |
| 1.3. | Засгийн газраас олгосон зөвшөөрлийн огноо, дугаар:  | Монгол улсын Засгийн газрын 2024 оны 05 сарын 08-ны өдрийн 201 тоот тогтоол              |
| 1.4. | Бондын нэр:   | Улаанбаатар бонд   |
| 1.5. | Зэрэглэл /зэрэглэл тогтоолгосон бол/:   | Зэрэглэл тогтоолгоогүй   |
| 1.6. | Зэрэглэл тогтоосон байгууллагын нэр /зэрэглэл тогтоолгосон бол/:                              | Зэрэглэл тогтоолгоогүй   |
| 1.7. | Тоо ширхэг:   | 5,000,000 (таван сая) ширхэг хүртэл  |





- 1.8. Нэрлэсэн үнэ: 100,000 (зуун мянга) төгрөг
- 1.9. Хугацаа: 3 жил хүртэлх
- 1.10. Хүү, төрөл /тогтмол, хөвөгч г.м/: 15.2% хүртэлх
- 1.11. Хүү, үндсэн төлбөр төлөх давтамж, хугацаа: Хүү төлөх давтамж: Хагас жил тутам  
Үндсэн төлбөр төлөх хуваарь: Хугацааны эцэст
- 1.12. Бусад нөхцөл /хугацаанаас өмнө хөрөнгө оруулагч эргүүлэн худалдах, бонд гаргагч худалдаж авах нөхцөлтэй г.м/: -
- 1.13. Татан төвлөрүүлэхээр төлөвлөсөн мөнгөн хөрөнгийн хэмжээ: 500,000,000,000 (таван зуун тэрбум) төгрөг хүртэлх\*  
\*Бондын татан төвлөрүүлсэн үнийн дүнгээс тухай бүр андеррайтерийн шимтгэлийг суутган тооцно.
- 1.14. Тодорхой үе шаттай буюу Бонд гаргах хөтөлбөр хэрэгжүүлэх бол дэлгэрэнгүй мэдээлэл: Бондыг СЗХ-ны "Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам"-ын 4.3.1-д заасны дагуу 24 хүртэлх сарын хугацаатай бондын хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. Хөтөлбөрийн хүрээнд хэсэгчлэн санал болгох тухай бүр бондуудын хүү, хугацаа, санал болгох үнийн дүн болон бусад нөхцөлийг Нийслэлийн Засаг Дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч шийдвэрлэнэ. СЗХ-ны "Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам"-ын 6.5-д заасны дагуу бондыг анхдагч зах зээлд санал болгож, захиалгыг эхлүүлэх тухай мэдэгдлийг Нийслэлийн Засаг даргын болон төсөвт тусгасан тухай НИТХ-ийн шийдвэрийн хамт уг ажиллагааг эхлэхээс ажлын 5-аас доошгүй өдрийн өмнө хороонд мэдэгдэнэ.
- 1.15. Стратегийн хөрөнгө оруулагч болон/эсхүл олон нийтэд санал болгон худалдахаар төлөвлөсөн хугацаа: Санхүүгийн зохицуулах хорооны "Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам"-ын 4.3-д заасны дагуу Бондын анхны нийлүүлэлтийг Хороонд бүртгүүлснээс 6 сарын дотор, үлдэх дүнг хөтөлбөрийн хугацаанд багтаан санал болгоно.  
Зах зээлийн нөхцөл байдал болон хөрөнгө оруулагчдын хандлагыг харгалзан Нийслэлийн

2024 /05/ 31





Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн тухай бүр шийдвэрлэсний дагуу тус журмын 6.5-д тусгаснаар бондыг анхдагч зах зээлд санал болгож, захиалгыг эхлүүлэх тухай мэдэгдлийг Нийслэлийн Засаг даргын болон төсөвт тусгасан тухай НИТХ-ийн шийдвэрийн хамт уг ажиллагааг эхлүүлэхээс ажлын таваас доошгүй өдрийн өмнө Хороонд мэдэгдэж анхдагч зах зээлийн арилжааг зохион байгуулна.

1.16. Үнэт гэрчлэгдэх оруулагчийн үүрэг: цаасаар хөрөнгө эрх,

**Бонд эзэмшигчийн эрх, үүрэг:**

- Анхдагч зах зээлээс худалдан авсан бондоо хоёрдогч зах зээл дээр чөлөөтэй худалдах эрхтэй.
- Бондын үндсэн болон хүүгийн төлбөрийг заасан хуваарийн дагуу бүрэн төлөхийг Үнэт цаас гаргагчаас шаардах эрхтэй бөгөөд тус эрхээ өөрөө эсхүл төлөөлөгч, өмгөөлөгчөөр дамжуулан эдэлнэ.
- Бондтой холбоотой аливаа санал, гомдлыг Андеррайтерт мэдэгдэнэ.
- Бонд эзэмшигч нь хуулиар хүлээсэн татвар, арилжааны шимтгэл болон бусад гарах зардлыг өөрөө хариуцна.
- Бонд эзэмшигчийн бондын захиалгын төлбөрт төлсөн мөнгөн хөрөнгө нь түүний хууль ёсны үйл ажиллагаанаас олсон орлого бөгөөд "Мөнгө угаах, терроризмтой тэмцэх тухай хууль"-ийн дагуу холбогдох шалгуурыг хангасан, эрх зүйн аливаа доголдолгүй, маргаангүй байна.
- Бондын үндсэн нөхцөлүүдийг бүрэн хүлээн зөвшөөрч, албан мэдэгдэл болон бусад холбогдох мэдээлэлтэй танилцсаны үндсэн дээр хөрөнгө оруулалтын шийдвэрийг гаргана.
- Хууль, тогтоомжид заасан бусад эрх, үүрэг.


2024.05.31



1.17. Андеррайтер, үнэт цаас гаргахтай холбоотойгоор мэргэжлийн үйлчилгээ үзүүлж байгаа бусад этгээд, тэдгээртэй байгуулсан гэрээгээр хүлээсэн эрх, үүрэг, хариуцлага:

Андеррайтер нь Үнэт цаас гаргагч "Улаанбаатар хот"-ын бонд санал болгон гаргах ажиллагаанд 2024 оны 05 сарын 30-ны өдөр андеррайтерийн гэрээ байгуулсан. "Андеррайтерийн зөвлөх үйлчилгээний гэрээ"-ний хүрээнд талууд дараах эрх, үүрэгтэй байна:

**Зөвлөх /Андеррайтер/-ийн эрх, үүрэг:**

- Гүйцэтгэгч нь ажлыг техникийн тодорхойлолтод заасан шаардлагад





эрх,  
хариуцлага:

үүрэг,

нийцүүлэн гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэж, Захиалагчид хүлээлгэн өгнө.

- Гүйцэтгэгч нь ажлын талбайд ажиллах хүч (удирдах ажилтан, инженер, техникийн ажилтан гэх мэт) болон ашиглаж буй тоног төхөөрөмж, машин механизмын дэлгэрэнгүй жагсаалт, мэдээллийг Захиалагчид өгнө
- Зөвлөх нь энэхүү гэрээнд заасан үйл ажиллагааг Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэн мэргэжлийн түвшинд хийж гүйцэтгэнэ.
- Ажил гүйцэтгэхэд шаардагдах материал, техник, тоног төхөөрөмж, машин механизм, сэлбэг хэрэгсэл, баримт бичгүүд, Гүйцэтгэгчийн түр ба байнгын ажлын байранд ажиллах ажилтан болон үйлчилгээг гүйцэтгэгч хариуцна.
- Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны нийлүүлэлт болон арилжааг гүйцэтгэх үүрэгтэй.

**Захиалагч /Үнэт цаас гаргагч/-ийн эрх, үүрэг:**

- Захиалагч нь ажлын үр дүнг хүлээн авч, гэрээнд заасан хугацаанд үнийг төлнө.
- Захиалагч хууль тогтоомж болон гэрээнд заасан баримт бичиг, зөвшөөрлийг Гүйцэтгэгчид зохих ёсоор гаргаж өгнө.
- Захиалагч нь үйлчилгээ авахтай холбоотой гаргаж өгсөн ажлын даалгавар, техникийн нөхцөл зэрэг баримт бичгийн алдаатай холбоотой үр дагаврыг хариуцна.

1.18. Анхдагч зах зээлд санал болгох арга, хэлбэр:

- Арилжаа эрхлэх байгууллагаар дамжуулан тогтсон үнийн аргаар олон нийтэд санал болгох
- Андеррайтерийн компаниар дамжуулан дараах аргаар олон нийтэд санал болгох
- Захиалгын бүртгэлийн арга
- Тогтсон үнийн арга





## 2. Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

- 2.1. Улаанбаатар /Нийслэл/ хот нь үнэт цаас гаргах замаар татан төвлөрүүлсэн хөрөнгөөр дараах төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр төлөвлөсөн.
- 2.1.1. Үйл ажиллагаа – 1
- 2.1.1.1. **Бөөрөлжүүтийн цахилгаан станц**
- 2.1.1.2. Төсөвт өртөг, татан төвлөрүүлсэн хөрөнгөнд эзлэх хувь: 300 тэрбум төгрөг хүртэл буюу 60 хувь
- 2.1.1.3. Хэрэгжүүлэгч этгээд:
- Орон нутаг
  - Хувийн хэвшил
  - Төр, хувийн хэвшлийн түншлэл
- 2.1.1.4. НЗДТГ-аас тус компанийн итгэмжлэн удирдаж буй Нийслэлийн хөгжлийн сан хувийн хаалттай ХОС-руу хөрөнгө оруулалт хийж сангийн нэгж эрхийг эзэмшиж, улмаар тус сангаас Бөөрөлжүүтийн цахилгаан станцын төсөл рүү хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөж байна.
- 2.1.1.5. Бэлэн байдлын үнэлгээ
- Зураг төсөл
  - Техник, эдийн засгийн үнэлгээ
  - Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ
  - Туслан гүйцэтгэгч
  - Бусад мэргэжлийн байгууллагаас гаргасан дүгнэлт
  - Шаардлагатай бусад
- 2.1.1.6. Тухайн үйл ажиллагаа нь төр, орон нутгийн бодлого, стратегид нийцсэн байдал, нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөө, хүрэх үр дүн, учирч болзошгүй эрсдэл зэрэг болон бусад дэлгэрэнгүй мэдээлэл

2024.05.31



### Нийслэлийн бодлого стратегид нийцсэн байдал:

- ✓ “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого 4.2.8. Цахилгаан станцуудыг өргөтгөж, цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц, шинэ эх үүсвэрийг барьж, цахилгаан эрчим хүчээр дотоодын хэрэгцээг бүрэн хангасан байна.
- 8.1.6. Эрчим хүчний бие даасан нэгдсэн системтэй болж, сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрүүдийг хоршин ашиглах ухаалаг тогтолцоонд шилжүүлж, эрчим хүч экспортлогч болсон байна.
- 9.3.6. Хотын гудамж замын иж бүрэн сүлжээг бий болгоно.
- ✓ Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл 9.10. Эрчим хүчний ашиглалтын үр ашгийг өсгөж, дэд бүтцийг өргөжүүлэн, технологийн шинэчлэл хийж, хүн амыг тогтвортой эрчим хүчээр хангана.
- 9.11 Дулааны эрчим хүчний дотоодын хэрэгцээг бүрэн хангах эх үүсвэрийн чадлын нөөцийг бий болгоно.





**Нийгэмд үзүүлэх үр нөлөө:**

- Төвийн бүсийн эрчим хүчний системийн оргил ачаалал 2022 онд 1469 МВт хүрч өмнөх оноос 6 хувиар, 2023 онд 1636 МВт-д хүрч 11.3 хувиар өсөж эрчим хүчний хэрэглээ 200-250 МВт-аар хэтэрснээр нийлүүлэлтийг хязгаарлах нөхцөл байдалд хүрсэн. Цаашид өсөн нэмэгдэж байгаа эрчим хүчний хэрэглээг хангах, иргэдийн ая тухтай амьдрах орчныг бүрдүүлэх, Улаанбаатар хотод томоохон төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх, эрчим хүчний суурь хэрэгцээг хангах шаардлага тулгараад байна.

**Хүрэх үр дүн:**

- Улаанбаатар хотоос 120 км зайд Төв аймгийн Баянжаргалан сумын нутагт орших Бөөрөлжүүтийн хүрэн нүүрсний ордыг түшиглэн 300 МВт-ын цахилгаан станцыг барих ажил үргэлжилж байна. Төслийн эхний ээлжийн 150 МВт-ын цахилгаан станцын барилга угсралтын ажил 2024 оны 10 дугаар сард дуусах бол 2 дахь ээлжийн 150 МВт-ын цахилгаан станцын барилга угсралтын ажил 2025 оны 9 дүгээр сард дуусахаар төлөвлөгдсөн байна. Цаашид тус цахилгаан станц нь үе шаттайгаар 2028 он хүртэл 600 МВт-ын хүчин чадал бүхий станц болох төлөвлөлттэй.
- Бөөрөлжүүтийн цахилгаан станцын төслийг эрчимжүүлэх, Улаанбаатар хотын эрчим хүчний суурь хэрэглээг хангах зорилгоор бондын эх үүсвэрээс 300.0 тэрбум төгрөгийн санхүүжилтийг зээл хэлбэрээр олгохоор тооцсон бөгөөд Нийслэлийн зүгээс тухайн төсөл хэрэгжүүлэгч компанийн хувьцааг барьцаалах, бондын санхүүжилтийн эргэн төлөлтийг хүүгийн хамт төсөл хэрэгжүүлэгч эргэн төлөхөөр төлөвлөсөн.

2024.05.31

2.1.2 Үйл ажиллагаа – 2

2.1.2.1. Ариутгах Бохир усны Туул-1 коллектор болон үерийн байгууламж

2.1.2.2. Төсөвт өртөг, татан төвлөрүүлсэн хөрөнгөнд эзлэх хувь: 50 тэрбум төгрөг хүртэл буюу 10 хувь хүртэл

Ариутгах Бохир усны Туул-1 коллектор: 40 тэрбум төгрөг хүртэл

Үерийн хамгаалалтын шугам сүлжээ, барилга байгууламж: 6 тэрбум төгрөг хүртэл

Андеррайтинг үйлчилгээний зардал: 4 тэрбум төгрөг хүртэл


2.1.2.3. Хэрэгжүүлэгч этгээд:

- Орон нутаг
- Хувийн хэвшил
- Төр, хувийн хэвшлийн түншлэл

2.1.2.4. Бэлэн байдлын үнэлгээ

- Зураг төсөл
- Техник, эдийн засгийн үнэлгээ
- Байгал орчны нөлөөллийн үнэлгээ
- Туслан гүйцэтгэгч
- Бусад мэргэжлийн байгууллагаас гаргасан дүгнэлт
- Шаардлагатай бусад





2.1.2.5 Тухайн үйл ажиллагаа нь төр, орон нутгийн бодлого, стратегид нийцсэн байдал, нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөө, хүрэх үр дүн, учирч болзошгүй эрсдэл зэрэг болон бусад дэлгэрэнгүй мэдээлэл:

**Нийслэлийн бодлого стратегид нийцсэн байдал:**

• **Алсын хараа-2050**

Инженерийн шугам сүлжээний найдвартай, хэвийн ажиллагааг хангах Зорилго 6. Байгаль орчинд ээлтэй ногоон хөгжлийг эрхэмлэн экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалж, байгаль орчны тогтвортой байдлыг ханган үр өгөөжийг нь өнөө болон ирээдүй хойч үе хүртэх нөхцөлийг бүрдүүлж, хүний амьдралын чанарыг сайжруулна.

**Нийгэмд үзүүлэх үр нөлөө:**

Засгийн газрын 2021 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн хуралдааны 52 дугаар тэмдэглэлээр БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлээр баригдаж буй Шинэ төв цэвэрлэх байгууламжийн туршилт тохируулгын ажил 2024 оны 08 дугаар сарын 26-ны өдрөөс эхлэхээр төлөвлөгдөж байна. Төв цэвэрлэх байгууламжийг бүрэн ашиглалтад оруулахад Улаанбаатар хотын бохир усны “Туул -1” гол цуглуулагч шугамын барилга байгууламжийн ажлыг нэн яаралтай барьж дуусгаж, хамт ашиглалтад оруулах шаардлагатай. Энэхүү төсөл бүрэн ашиглалтад орсноор одоо байгаа Ф1200 мм, Ф1400 мм-ийн гол цуглуулах шугамын ачааллыг 35%-аар бууруулах бөгөөд Гачуурт, Хужирбулан, Улиастай, Налайх, Амгалан, Шархад, Дамбадаржаа, 7 буудал, Баянхошуу, Толгойт, Баянголын ам гэх зэрэг гэр хорооллын бүсэд баригдах орон сууцны хороолол, хотхоны бохир усыг хүлээн авах нөхцөл бүрдэнэ.

**Хүрэх үр дүн:**

“Туул 1” коллектор нь Улаанбаатар хотын бохир усны шугамын ачааллыг авах гол шугам бөгөөд одоо байгаа болон ирээдүйд барих барилга байгууламжийн бохир усыг татан зайлуулах хүчин чадал бүхий стратегийн ач холбогдолтой инженерийн шугам сүлжээ бий болох.

**Учирж болзошгүй эрсдэл:**

- Байгалийн гэнэтийн үер усны эрсдэл
- Санхүүжилтийн үе шатнаас хамааран төсөл удаашрах
- Үнийн өсөлт

2.1.3. Үйл ажиллагаа – 3

2.1.3.1. Авто зам, замын байгууламжийн засвар, шинэчлэлтийн ажил

2.1.3.2. Төсөвт өртөг, татан төвлөрүүлсэн хөрөнгөнд эзлэх хувь: 150 тэрбум төгрөг хүртэл буюу 30.0 хувь хүртэл





2.1.3.3. Хэрэгжүүлэгч этгээд:

- Орон нутаг
- Хувийн хэвшил
- Төр, хувийн хэвшлийн түншлэл

2.1.3.4. Бэлэн байдлын үнэлгээ:

- Зураг төсөл
- Техник, эдийн засгийн үнэлгээ
- Байгал орчны нөлөөллийн үнэлгээ
- Туслан гүйцэтгэгч
- Бусад мэргэжлийн байгууллагаас гаргасан дүгнэлт
- Шаардлагатай бусад

2.1.3.5 Тухайн үйл ажиллагаа нь төр, орон нутгийн бодлого, стратегид нийцсэн байдал, нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөө, хүрэх үр дүн, учирч болзошгүй эрсдэл зэрэг болон бусад дэлгэрэнгүй мэдээлэл:



**Нийслэлийн бодлого стратегид нийцсэн байдал:**

- *Алсын хараа-2050*

Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулахад нөлөө үзүүлэх үндсэн ба гол авто замын сүлжээг хөгжүүлэх, өргөтгөх шинэчлэх

- *Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл:*

9.19 Авто зам, дугуйн зам, явган замын нөхцөлийг сайжруулан, гол, туслах гудамж болон хорооллын доторх замыг өргөтгөн, шинэчилж, авто замыг шинээр барьж, үндсэн сүлжээг нэмэгдүүлэн, хөгжүүлнэ.





**Нийгэмд үзүүлэх үр нөлөө:**

- Улаанбаатар хотын хатуу хучилттай авто замын сүлжээ өнөөгийн байдлаар нийт 1231.3 км байна. Сүүлийн жилүүдэд Улаанбаатар хотын хүн ам, тээврийн хэрэгслийн тоо эрс нэмэгдэж байгаагаас авто замын сүлжээ өнөөдрийн хэрэгцээ шаардлагыг хангаж чадахгүйд хүрсэн.
- Улаанбаатар хотын авто замын үндсэн хөрөнгийн үнэлгээ өнөөгийн байдлаар 1.5 их наяд бөгөөд 10 жилийн хугацаанд засвар шинэчлэлт хийгдэхгүй тохиолдолд 420.0 тэрбум төгрөг болж буурах тооцоололтой. Мөн хотын гол болон туслах гудамж замуудыг насжилтаар нь авч үзвэл:
  - о 1-5 жилийн насжилттай авто зам 164.1км буюу 22%
  - о 5-10 жилийн насжилттай авто зам 306.9 км буюу 41%
  - о 10-15 жилийн насжилттай авто зам 237.2 км буюу 32% тус тус эзэлж байна.
- Авто замын өнөөгийн ашиглалтын байдлыг харахад 82.2% нь засвар, шинэчлэлт хийх шаардлагатай гэсэн судалгааг холбогдох байгууллагаас гарсан байна. Мөн олон улсад авто зам ашигласны төлбөр дунджаар километр тутамд 8 цент байгаа бол Улаанбаатар хотын хувьд 2 төгрөг буюу дэлхийн дунджаас 160 дахин бага байна.







Улаанбаатар хотын гол болон туслах, гудамж замуудын хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх, авто замын сүлжээг өргөтгөн шинэчлэх, засварлах ажлын хүрээнд дотоод бондын эх үүсвэрээс 150.0 тэрбум төгрөгөөр нийт 30 байршилд 1,195,000 м2 талбайг хамарсан засвар, шинэчлэлтийн ажил хийхээр төлөвлөж байна.

**Учирж болзошгүй эрсдэл:**

- Байгалийн давагдашгүй хүчин зүйл /бороо, цас/, цаг агаарын нөхцөл байдлаас хамаарч төсөл, арга хэмжээ хугацаандаа хэрэгжихгүй байх.
- Барилгын бараа материалын үнийн өсөлт, тээвэрлэлтийн тогтворгүй байдал эрсдэл үүсгэх магадлалтай.

**2.2 Хориглох үйл ажиллагааны жагсаалт**

Нийслэл нь Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль, Өрийн удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль болон бусад холбогдох хууль, журамд зааснаас бусад үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно.

Улаанбаатар хот /Нийслэл/ нь Санхүүгийн зохицуулах хорооны "Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам"-ын 3.4.5-д заасны дагуу энэхүү мэдэгдэлд тусгасан төсөл, арга хэмжээ болон бонд гаргахтай холбоотой гарах зардлаас бусад үйл ажиллагааг тус бондын татан төвлөрүүлсэн хөрөнгөөр санхүүжүүлэхгүй.

**2.3 Чөлөөт хөрөнгийн удирдлагатай холбоотой мэдээлэл**

Нийслэл нь татан төвлөрүүлсэн хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалтыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс төсөл тус бүрээр тайлагнаж ажиллана.

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, Төрийн сангийн хэлтэс нь бондын хөрөнгийн зарцуулалтын ил тод байдлыг хангаж ажиллана.

**2.4 Шаардлагатай бусад мэдээлэл:**

-

**3. Тайлагнал**

**3.1. Тайлангийн нэр, олон нийтэд хүргэх хэлбэр, давтамж**


**Тайлангийн нэр:** Зарцуулалтын тайлан

**Олон нийтэд хүргэх хэлбэр, давтамж:**

Нийслэл нь бондын арилжааг хийсэн өдрөөс тухайн бондын хугацаа дуусах хүртэлх хугацаанд татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайланг Санхүүгийн зохицуулах хорооны "Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам"-ын хавсралт 8-д тусгасан маягтуудын дагуу улирал тутамд дараа сарын 10-ны өдрийн дотор, жилийн тайланг дараа оны 02 сарын 10-ны дотор, Хороо, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн байгууллага, арилжаа эрхлэх байгууллагад тус тус хүргүүлж, нийтэд мэдээлнэ.

**Тайлангийн нэр:** Хэрэгжүүлэх үйл ажиллагааны хэрэгжилтийн тайлан, мэдээлэл





Нийслэлийн үнэт цаасыг 24 сар хүртэлх хөтөлбөрийн хүрээнд хэсэгчлэн нийтэд санал болгох ба Санхүүгийн Зохицуулах Хорооны "Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам"-ын 6.6-д тусгасны дагуу анхдагч зах зээлийн арилжааг зохион байгуулах мэдэгдэлд энэхүү баримт бичигт тусгасан хэрэгжүүлэх үйл ажиллагааны хэрэгжилтийн тайлан мэдээллийг хавсарган хүргүүлнэ.

3.2. Хэрэгжүүлэх үйл ажиллагааны явц, үе шат, үр дүнг илэрхийлэх чанарын болон тоон үзүүлэлтүүд



Бондын татан төвлөрүүлсэн хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээний явц, үе шат, үр дүнг дараах журмын хүрээнд холбогдох хэлтсүүд үнэлэн, хяналт тавьж, нийтэд мэдээлж ажиллана.

- Монгол улсын Засгийн газрын 2020 оны 206 тоот тогтоолын "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам болон "Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх журам"-д заасны дагуу хяналт шалгалт, үнэлгээ хийнэ.  
"Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх журам" нь Хөгжлийн бодлогын баримт бичиг болон хууль тогтоомж, шийдвэрийн хэрэгжилтийг нийслэлийн нутаг дэвсгэрт зохион байгуулах, тэдгээрийн хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн, нийслэлийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг үнэлж, дүгнэхтэй холбогдсон харилцааг зохицуулдаг.
- Санхүүгийн Зохицуулах Хорооны "Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам"-ын 6.6-д тусгасны дагуу анхдагч зах зээлийн арилжааг зохион байгуулах мэдэгдэлд энэхүү баримт бичигт тусгасан үйл ажиллагааны хэрэгжилтийн тайлан мэдээллийг хавсарган Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржид хүргүүлж, нийтэд тухай бүр мэдээлнэ.

3.3. Үйл ажиллагааны тайлан хариуцсан ажилтан /алба, нэгж/-ны холбоо барих хаяг, утас, цахим хаяг

Овог нэр: Л.Эрдэнэбадрах  
Албан тушаал: НЗДТГ-ын СХОГ-ын СТСХ-ийн дарга  
Хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 15-р хороо, вега сити, 401 тоот  
Утас: +976-99090549  
Цахим хаяг: erdenebadrakh.l@ulaanbaatar.mn






**БАТАЛГААЖУУЛСАН:**

Овог, нэр: **Хишгээ НИМБААТАР**  
Албан тушаал: Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч

Гарын үсэг: .....  
(Тамга/тэмдэг)



Овог, нэр: **Бүрэнмэнд ЛХАГВАДОРЖ**  
Албан тушаал: Андеррайтерийн "БиДиСЕК ҮЦК" ХК-ийн Гүйцэтгэх захирал

Гарын үсэг: .....  
(Тамга/тэмдэг)




Овог, нэр: **Нямандэлэг МАНДУУЛ**  
Албан тушаал: Нийслэлийн Засаг даргын Санхүү, дэд бүтцийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан зөвлөх

Гарын үсэг: .....  
(Тамга/тэмдэг)

Овог, нэр: **Хүрлээ МӨНХЗУЛ**  
Албан тушаал: Албан тушаал: "Эм Ай Си Си ҮЦК" ХХК-ийн Гүйцэтгэх захирал

Гарын үсэг: .....  
(Тамга/тэмдэг)



Овог, нэр: **Луулай ХОСБАЯР**  
Албан тушаал: Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга

Гарын үсэг: .....  
(Тамга/тэмдэг)

